

SMITTSKYDDSBLAD

Patientinformation

Latent tuberkulos när behandling ges

Översatt till mongoliska

Version 2022-04-11

Идэвхгүй сүрьеэ, өвчтөнд өгөх мэдээлэл

Урьдчилан сэргийлэх эмчилгээ хийх нь. Халдвар хамгааллын эмч нарын мэдээллийн хуудас.

Сүрьеэ хэрхэн халдварлах вэ?

Уушгиндаа сүрьеэтэй хүн тасалгаанд ханиалгахад бусдад халдвар тараана. Өөр эхртэнд байрлах сүрьеэ ба идэвхгүй сүрьеэ халдварлахгүй. Бэлгийн бойжилтын өмнөх насны хүүхэд халдварлах нь ховор. Халдвар авах эрсдэл нь нэг өрөөнд удаан хугацаанд хамт байх, жишээ нь нэг өрхөд амьдрахад өндөр байна.

Идэвхгүй сүрьеэ гэж юу вэ?

Халдвар авсан бүх хүн сүрьеэгээр өвчлөхгүй. Ихэнх хүмүүсийн биеийн дархлаа бактерийн өсөлтийг зогсооно. Бактери биенд үлдэж, идэвхгүй байж болно. Ийм нөхцөл байдлыг **идэвхгүй сүрьеэ** гэнэ.

Идэвхгүй сүрьеэ бол өвчин биш

Цусны шинжилгээ (IGRA шинжилгээ) эсвэл арьсны сорил (сүрьеэний сорил) хийлгэсний дараа идэвхгүй сүрьеэтэй гэсэн хариу авсан танд сүрьеэний шалтгаантай өвчний шинж тэмдэг илрэх ёсгүй. Та эдгээр бактерийг бусдад тараахгүй. Амьдралынхаа хожуу үед сүрьеэ тусах эрсдэл бий, гэхдээ энэ эрсдэл нь жижиг.

Зарим тохиолдолд урьдчилан сэргийлэх эмчилгээ хийдэг

Хожим өвчлөх өндөрсөн эрсдэлтэй зарим хүнд урьдчилан сэргийлэх эмчилгээ санал болгогддог. Эхний ээлжинд эмэгтэйчүүдэд жирэмсэн үед нь ба төрснийх нь дараа, хүүхэд залуучуудад, мөн суларсан дархлаатай буюу хорт хавдрын эмчилгээ, инсулинаар эмчлэх чихрийн шижинтэй, бөөрний хүнд өвчинтэй хүмүүст хамаатай. Урьдчилан сэргийлэх эмчилгээг заримдаа саяхан сүрьеэний халдварт өртсөн хүнд хийдэг.

Танд урьдчилан сэргийлэх эмчилгээ санал болгож байна

Та идэвхгүй сүрьеэтэй ба эмч танд урьдчилан сэргийлэх зорилгоор эмчилгээ санал болгож байна. Энэ нь таныг хожим сүрьеэгээр өвчлөх эрсдлийг багасгах зорилготой. Та хожим удаан хугацааны ханиалга (гурваас илүү долоо хоног), шөнийн хөлрөл, халуун, эсвэл хүсэхгүйгээр жин хасагдвал эмчтэй холбогдож сүрьеэний шинжилгээ хийлгүүлэх хэрэгтэй.

Холбоо барих мэдээлэл (Kontaktuppgifter)

Хүлээн авахын нэр (*Namn på mottagningen*)

.....

Таны уулзсан хүн (Таны уулзсан хүн)

Эмч (*Läkare*).....

Сувилагч (*Sjuksköterska*).....

Хүлээн авахын утасны дугаар / утасны цаг (*Telefonnummer/telefonid till mottagningen*)

.....